

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Компанийн тухай хуулийн 81-р зүйл, компанийн дүрмийн 4-р зүйлд зааснаар компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл

№	Овог нэр	Мэргэжил	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	Даваасүрэн Туул	Хуульч, эрх зүйч	"Силикат"ХК-ийн ТУЗ-ийн дарга	Үгүй
2	Цэрэннадмид Содбилэг	Филисофи	"Силикат" ХК-ийн гүйцэтгэх захирал	24,9%
3	Цэрэннадмид Сэргэлэн	Уулын баяжуулагч	"Силикат" ХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал	2%
4	Цэрэннадмид Болормаа	Нягтлан бодогч	"Силикат" ХК-ийн нягтлан бодогч	Үгүй
5	Дорж Энхболд	Бүрэн дунд	"Силикат" ХК-ийн борлуулалт хариуцсан менежер	12,77%
6	Володя Мөнхтуяа	Эдийн засагч	"Агч трейд" ХХК-ийн нягтлан бодогч	12,00%
7	Нямдаш Цогцлон	Хуульч	"Силикат" ХК-ийн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	7,5%
8	Мягмарсүрэн Наранзул	Барилгын материалын технологич	"Силикат" ХК-ийн технологич	Үгүй
9	Бямба Сэр-Од	Барилгын материалын технологич	"Силикат" ХК-ийн технологич инженер	Үгүй

ТУЗ-ын гишүүдийн мэдээлэл

### Гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүд, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүдийн мэдээлэл

Гүйцэтгэх захирал	Цэрэннадмидын Содбилэг нь 1968 оны 01 дүгээр сарын 16–нд Өвөрхангай аймгийн төвд төрсөн. 1976-1986 онд ерөнхий боловсролын сургуульд, 1993-1997 онд Тэнгэр дээд сургуулийн Философи социологийн ангийг социологич мэргэжлээр төгссөн. 1998-2007 онд Монгол газар компанид Дэд захирлаар, 2007 оноос Силикат ХК-д гүйцэтгэх
-------------------	--

	захиралаар ажиллаж байна.
<b>Ерөнхий инженер</b>	Галдаабаатар овогтой Ганболд нь 1970 оны 11 дүгээр сарын 25-нд Дархан хотод төрсөн. 1978-1988 онуудад ерөнхий боловсролын сургуульд суралцсан. 1994 онд Дархан хотын ТИС-ийн барилгын материал технологи инженерээр төгссөн. 2009 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн болзлыг хангасан.
<b>Үйл ажиллагаа эрхэлсэн захирал</b>	Жалбуу овогтой Ганболд нь 1965 оны 6 дугаар сарын 17-нд Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн. 1988 онд Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн их сургуулийг Агро-химич мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд 2000 онд ОХУ-ийн Екатеринбург хотын Уралын их сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр төгсчээ. Тэрбээр 1988-1993 онд Ургамал Газар Тариалангын Эрдэм шинжилгээний хүрээлэнд, 2001-2009 онуудад “Агч Формула” ХХК-нд захиралаар ажиллаж байсан бөгөөд 2009 оноос эхлэн “Силикат” ХК-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захиралаар ажиллаж байна.
<b>Ерөнхий нягтлан бодогч</b>	Дэжмаа овогтой Уранчимэг нь 1958 оны 04 дүгээр сарын 10-нд Завхан аймгийн Алдархаан суманд төрсөн. 1965-1975 онд Завхан аймгийн 10 жилийн сургуулийг, 1977 онд Худалдааны техникумын Нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 1981 онд МУИС-ийн ЭЗ-ийн факультетийг нягтлан бодогч-эдийн засагч мэргэжлээр, 1998 онд Удирдлагын академийн эдийн засгийн бакалавр мэргэжлээр тус тус төгссөн. Монгол Улсын хугацаагүй эрхт мэргэшсэн нягтлан бодогч, Монгол Улсын аудиторын болзлыг хангасан. <ul style="list-style-type: none"> <li>- 1977-1986 онд Завхан аймгийн Бөөний баазад ахлах нягтлан бодогч</li> <li>- 1986-1991 онд Завхан аймгийн Хот тохижилтын газрын ерөнхий нягтлан бодогч</li> <li>- 1991-2003 онд Завхан аймгийн Ус сувгын газрын ерөнхий нягтлан бодогч</li> <li>- 2003-2008 онд УБ аудит корпорацид аудит</li> <li>- 2008 оноос Силикат ХК-д ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байна</li> </ul>
<b>Механик инженер</b>	Сайнбаяр овогтой Баярсайхан нь 1970 онд Дархан хотод төрсөн. 1978-1988 онд Булган аймгийн 10 жилийн сургуулийг, 1988-1993 онд Белорусь улсын Мотиллов хотод Барилгын техникумын сантехникийн техникч мэргэжлээр, 1993-1997 онд ШУТИС-ийн Дархан дахь салбарын БМҮТТ-ийн инженер мэргэжлээр тус тус төгссөн. 1997-2009 онуудад

---

	УБ хотын “Хөнгөн бетон” ХК-ны үйлдвэрт механик инженерээр ажилласан. 2011 оноос “Силикат” ХК-д механик инженерээр ажиллаж байна. 2009 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн цол горилсон.
<b>Хөдөлмөр хамгаалалын инженер</b>	Сарынд овогтой Асылхан 1945 онд Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд төрсөн. 1958-1968 онд Баян-Өлгий аймгийн 10 жилийн сургуулийг, 1968-1973 онд ЗХУ-ын Свердловск хотын Политехникийн дээд сургуулийг дулааны инженер мэргэжлээр төгссөн. 1973-2005 онд Дархан хотын Дулааны Цахилгаан станцад дулааны инженер, зуухны засварын инженер, ИТАлбаны ахлах инженер, 2005-2007 онд Ноёд группын Дулааны инженерээр, 2007 оноос “Силикат” ХК-д дулааны инженер, хөдөлмөр хамгаалалын инженерээр тус тус ажилласан. 2006 онд Монгол Улсын мэргэшсэн инженерийн болзлыг хангасан.

---